



## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 20 өдөр


Дугаар A1243

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай тохиолдолд хилийн боомт болон харьяалах, эсхүл холбогдох улсад хүргэх “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөрчил шалган шийдвэрлэх газар (Х.Бэхбат), Санхүү, хангалт үйлчилгээний газар (Ж.Солонго)-т тус тус үүрэг болгосугай.



Гадаадын иргэн, харьяатын газрын даргын  
2024 оны 06 дугаар сарын ~~20~~<sup>20</sup>-ны өдрийн  
А/20.. дугаар тушаалын хавсралт

## ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАХ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-ийг шаардлагатай тохиолдолд хилийн боомт болон харьяалах, эсхүл холбогдох улсад хуяглан хүргэх ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйл болон Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох тухай журмын 3 дугаар зүйлд заасныг баримтална.

### Хоёр. Хэрэгжүүлэх ажиллагаа

1.1. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх газрын даргын томилсон гадаадын иргэний хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

1.2. Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга нь Монгол Улсаас албадан гаргах шийдвэр гарсан нэгээс илүүгүй гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хоёр, эсхүл түүнээс дээш гадаадын иргэний хяналтын улсын байцаагч болон уг ажиллагааг ахлах албан хаагчийг томилно.

1.3. Монгол Улсаас албадан гаргах шийдвэр гарсан тухайн гадаадын иргэн нь албадан гаргах ажиллагаанд саад учруулсан буюу саад учруулж болзошгүй, эсхүл гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй эрсдэлтэй гэж үзсэн, эсхүл зайлшгүй хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх шаардлагатай тохиолдолд гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн тоо харгалзахгүйгээр томилон ажиллуулна.

1.4. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхэд томилогдсон гадаадын иргэний хяналтын улсын байцаагч аюулгүй байдал, хувийн болон албаны бэлтгэлийг хангаж, газар орны болон цаг уурын нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч хэрэглэх холбоо, техник болон тээврийн хэрэгсэл, тусгай хэрэгслийг хангаж, хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг тооцно.

1.5. Хуяглан хүргэхээр томилогдсон гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь тодорхой эрсдэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдал бий болсон буюу шаардлагатай тохиолдолд, эсхүл тогтоосон хугацаанд хуяглан хүргэх боломжгүй болсон бол Зөрчил шалган шийдвэрлэх газрын даргад нэн даруй мэдэгдэж, тухай бүр заавар, чиглэл авна.

1.6. Хуяглан хүргэх ажиллагаанд автомашин ашиглах тохиолдолд тээврийн хэрэгслийн жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг

Урьдчилан хангасан байна. Хуяглан хүргэх жолооч зайлшгүй шаардлагын улмаас тээврийн хэрэгслийг зогсоох үед хөдөлгүүрийг унтрааж, түлхүүрийг биедээ авах бөгөөд жолоог бусдад шилжүүлэхгүй.

1.7. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх хилийн боомт хүртэл болон харьялах, эсхүл холбогдох улсад (хилийн чанадад) явах чиглэл (маршрут)-ээс хамаарч төв болон тухайн харьялах орон нутаг дахь нэгж, төлөөлөл нь уг ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана. Тухайн орон нутаг дахь нэгж нь хилийн боомтод хуяглан хүргэгдсэн гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гарах чиглэлд нэвтрүүлэх ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулан ажиллах үүрэгтэй.

#### **Гурав. Ажиллагааны зардал**

3.1. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхээр томилогдсон гадаадын иргэний хяналтын улсын байцаагч болон жолоочийн, уналга, хоноглох орон байр, хүнс, ашиглагдах автотээврийн хэрэгслийн шатахуун (хуяглан хүргэх ажиллагааг агаарын, төмөр замаар гүйцэтгэх тохиолдолд вагон)-ы зардлыг албадан гаргах ажиллагааны зардлаас гаргана.

3.2. Энэ журмын 3.1-д заасан гадаадын иргэний хяналтын улсын байцаагч болон жолоочийн байр, хоолны зардлыг тооцохдоо Монгол Улсын сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” хэмжээгээр тогтооно.

3.3. Гадаадын иргэнийг хуяглан хүргэх ажиллагаанд ашиглагдах автотээврийн хэрэгслийн шатахуун (хуяглан хүргэх ажиллагааг агаарын, төмөр замаар гүйцэтгэх тохиолдолд вагон)-ы зардлыг хилийн боомт болон хилийн чанадад хүртлэх ирж, очих чиглэлийг урьдчилан тооцсон удирдамжид заасныг үндэслэн албадан гаргах ажиллагааны зардлаас олгоно.

-----оОо-----